

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар  
сарын ....-ний өдөр

Дугаар ....

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Импортлох согтууруулах ундаа, тамхины нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг нэгдүгээр, өргөдлийн загварыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга /Н.Цагаанхүү/, Татварын ерөнхий газрын даргын үүргийг гүйцэтгэгч /Д.Занданбат/, Гаалийн ерөнхий газрын дарга /Б.Асралт/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Энхбат/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг 2018 оны ..... дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

Монгол Улсын Засгийн газрын 201.оны  
... дугаар сарын ... –ны өдрийн ... дугаар  
тогтоолын нэгдүгээр хавсралт

**ИМПОРТЛОХ СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИНЫ НЭР ТӨРӨЛ, ТОО  
ХЭМЖЭЭГ ТОГТООХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Импортлох согтууруулах ундаа, тамхины нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалттай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрлийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно.

1.3. Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

1.4. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа ил тод, шударга байх зарчмыг баримтална.

1.5. Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын зар гаргах, үр дүнг мэдээлэх ажиллагааг цахим хэлбэрээр гүйцэтгэнэ.

**Хоёр. Согтууруулах ундаа, тамхины нэр төрөл, тоо хэмжээг тогтоох**

2.1. Тамхины хяналтын тухай хуулийн 6.10, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5.12-т заасны дагуу тоо хэмжээ тогтоох шийдвэрийг 1 жилийн өмнө гаргана.

2.2. Энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулах ажлын хэсгийн саналыг үндэслэн Тамхины хяналтын тухай хуулийн 6.10-т заасны дагуу тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд багтаан тусгай зөвшөөрлийн хугацаанд импортлох тамхины нэр төрөл, тоо хэмжээг БТКУС-ийн кодоод нийцүүлэн бүтээгдэхүүн тус бүрээр Засгийн газар тогтооно.

2.3. Энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулах ажлын хэсгийн саналыг үндэслэн Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5.12-т заасны дагуу тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд багтаан тусгай зөвшөөрлийн хугацаанд импортлох согтууруулах ундааны нэр төрөл, тоо хэмжээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн БТКУС-ийн кодоод нийцүүлэн бүтээгдэхүүн тус бүрээр тогтооно.

2.4. Импортлох согтууруулах ундааг нэр төрлөөр нь архи, уламжлалт технологиор үйлдвэрлэсэн согтууруулах ундаа, өвөрмөц дармал согтууруулах ундаа, дарс, шар айраг гэж ангилна.

2.5. Импортлох тамхийг нэр төрлөөр нь дүнсэн, янжуур, навчин /сигар/, усан хоолойгоор татах зориулалттай тамхи гэж ангилна.

## **Гурав. Сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсэг**

31. Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон ажлын хэсэг хариуцан зохион байгуулна.

32. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гааль, татвар, мэргэжлийн хяналт,эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллагын 1-ээс доошгүй төлөөллийг оролцуулна.

### **Дөрөв.Сонгон шалгаруулалтыг зарлах**

4.1. Энэ журмын 5.1, 5.2-т заасан баримт бичгийг хүлээн авах эцсийн хугацааг цахим зар гаргасан өдрөөс эхлэн тооцож ажлын 7 хоногоор тогтооно.

4.2. Сонгон шалгаруулалтын зарыг яамны цахим хуудаст байршуулах бөгөөд зар нь импортлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээний талаарх мэдээллийг агуулсан байна.

4.3. Хугацаа хоцорсон баримт бичгийг хүлээж авахгүй бөгөөд дутуу баримт бичгийг нөхөн бүрдүүлэхгүй. Тамга, тэмдэггүй, гарын үсэг зураагүй, огноо, дугааргүй баримт бичгийг хүчингүйд тооцно.

### **Тав.Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт**

5.1. Тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцогч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1- 11.1.2, 11.1.4, 11.1.6, 11.1.7-д зааснаас гадна дараахь баримт бичгийг ирүүлнэ:

5.1.1. Тамхи импортлох эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаарх эрүүл мэндийн дүгнэлтийг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тамхины төрөл тус бүрээр гаргуулсан баримт;

5.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт импортлох тамхинд агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлөөр баталгаажуулсан баримт;

5.1.3. Тамхи худалдан авах гэрээний хуулбар;

5.1.4.Гарал үүслийн гэрчилгээ;

5.1.5.Үйлдвэрийн чанарын сертификат;

5.1.6. Экспортлох эрх бүхий байгууллага буюу экспортлогч улсын нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, Монгол Улсад худалдаалахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэл;

5.1.7. Татварын албаны санал тодорхойлолт.

5.2. Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцогч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.2, 11.1.4, 11.1.6, 11.1.7-д зааснаас гадна дараахь баримт бичгийг ирүүлнэ:

5.2.1. Импортлох согтууруулах ундааны дээжийг нь хилийн гаалийн эрүүл ахуйн хяналт шалгалт хийлгүүлэн баталгаажуулсан баримт, дүгнэлт;

5.2.2. Импортлох согтууруулах ундааны дээжийг Мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, эрүүл ахуйн нөхцөл, эрүүл мэндийн дүгнэлтийг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас согтууруулах ундааны төрөл тус бүрээр гаргуулсан баримт;

5.2.3. ГЕГ-ийн хууль зөрчиж байгаагүй талаар тодорхойлолт /гаалийн мэдээллийн санд зөрчил бүртгэгдсэн эсэх талаар/;

5.2.4. Татварын албаны санал, тодорхойлолт;

5.2.5. Согтууруулах ундаа импортоор худалдан авах гэрээний хуулбар, тухайн согтууруулах ундааг экспортлох зөвшөөрөл;

5.2.6. Тохирлын гэрчилгээний хуулбар;

5.2.7. Импортлох хүнс нь зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан баримт.

5.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын санал, энэ журмын 5.1.1, 5.2.2-т заасан Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /МХЕГ-ын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газар/-ын эрүүл мэндийн дүгнэлтийг хамтарсан ажлын хэсэг байгуулан санал, дүгнэлт гаргасан байна.

5.4. Ажлын хэсэг нь статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээлэлд дурьдсан согтууруулах ундаа, тамхины үлдэгдэл хэмжээ, үйлдвэрлэлийн хэмжээ, эрэлт нийлүүлэлт, хэрэглээ, холбогдох олон улсын байгууллагын олон улс, бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого, стратеги, бусад оронтой байгуулсан гэрээ, хэлэлцээрийн шаардлага болон хуулийн этгээдийн өргөдөлд дурьдсан зөвшөөрөл авахаар хүссэн тоо хэмжээ, энэ журмын 5.1, 5.2-т заасан баримт бичгийг судалсны үндсэн дээр дор дурьдсан үзүүлэлтийг харгалзан тухайн хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох нэр төрөл, тоо хэмжээний талаар санал гаргана.

5.4.1. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн талаарх мэдээлэлд нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, жилийн эргэлт, борлуулалт, экспортод эзлэх хувь, одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээлэл;

5.4.2. Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлага: удирдлагын бүтэц, орон тоо, ажиллагсдын мэргэжил, мэргэшлийн ур чадвар, шинээр бий болгох ажлын байрны тоо;

5.4.3. Зах зээлийн судалгаа: зах зээлийн төлөв байдал, SWOT шинжилгээ, хэрэглэгчдийн тодорхойлолт;

5.4.4. Эдийн засгийн тооцоо: үндсэн үйлдвэрлэл, нийт орлого, борлуулалтын орлогын тооцоо, үйлдвэрлэлийн зардлын тооцоо, бүтээгдэхүүний өртгийн тооцоо, төлөвлөж байгаа борлуулалтын төлөвлөгөө, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн импортлох тооцоо;

5.4.5. Үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт технологи, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, агуулах, тээврийн хэрэгсэл, үүнээс нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт тоног төхөөрөмж, лонх, сав, баглаа боодол, шошгололт, бүтээгдэхүүн, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлт, үйлвэрлэл /агуулах/-ийн хүчин чадал, тээврийн хэрэгслийн хүрэлцээ, хангамж;

5.4.6. Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын дотоод хяналт, удирдлагын тогтолцооны бүрдүүлэлт, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, буцаан болон татан авалт, дотоод хяналт, шалгалтын бүртгэл;

5.4.7. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон галын аюулгүй байдлыг хангах нөхцөл, хөдөлмөрийн дотоод дүрэм;

5.4.8. Өмнө нь импортолсон бүтээгдэхүүний хэмжээ;

5.4.9. Дүгнэлтэд энэ журмын 5.4.1-5.4.4-д заасан тооцоо судалгаанд үндэслэн бүтээгдэхүүн импортлоход гарах үр дүн, эрсдэл зэргийг тооцоолсон мэдээллийг тусгана.

5.5. Шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэж болно.

5.6. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ажлын хэсгийн саналыг үндэслэн хүсэлт гаргагчид согтууруулах ундаа импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргана.

5.7. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ажлын хэсгийн саналыг үндэслэн хүсэлт гаргагчид тамхи импортлох импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох саналыг зохих хууль, журмын дагуу Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

5.8. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сонгон шалгаруулалтад тэнцсэн хуулийн этгээдэд импортлох согтууруулах ундаа, тамхины нэр төрөл, тоо хэмжээг заасан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгоно.

5.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олгосон нэр төрөл, тоо хэмжээнд багтаан импортолно.

5.10. Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг яамны цахим хуудаст байршуулж, хяналтын болон гаалийн байгууллагад хүргүүлнэ.

5.11. Сонгон шалгаруулалт явуулсантай холбогдох баримт бичгийг архивын нэгж болгон хадгална.

### **Зургаа.Согтууруулах ундаа, тамхи импортлох**

6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд дурьдсан тоо хэмжээний бүтээгдэхүүн импортлох боломжгүй болсон тохиолдолд энэ талаар хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 3 сараас багагүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

6.2. Энэ журмын 6.1-д заасны дагуу буцаасан согтууруулах ундаа, тамхины тоо хэмжээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нэмж олгоно.

6.3. Согтууруулах ундаа, тамхи импортлох боломжгүй талаар энэ журмын 6.1-т заасны дагуу мэдэгдээгүй нь уг хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах үед согтууруулах ундаа, тамхины тоо хэмжээг бууруулах үндэслэл болно.

6.4. Гаалийн байгууллага нь согтууруулах ундаа, тамхины импортын мэдээг хуулийн этгээдийн нэр, импортолсон согтууруулах ундаа, тамхины нэр төрөл, тоо, хэмжээг нэвтэрсэн хилийн боомтын нэрээр гарган, жил бүрийн 7 дугаар сар, дараа оны 1 дүгээр сард багтаан хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Долоо.Хариуцлага**

7.1. Энэхүү журмыг зөрчсөн хуулийн этгээд, албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Засгийн газрын 201. оны  
... дугаар сарын ... –ны өдрийн ... дугаар  
тогтоолын хоёрдугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ИМПОРТЛОХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ХҮССЭН ӨРГӨДӨЛ

|                                                                                                                                                                                                                                                                                                                                          |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|-------------------------------------|
| Огноо:                                                                                                                                                                                                                                                                                                                                   |  | Дугаар:           |                                                                                                                                | Шинээр олгох <input type="checkbox"/> Сунгах <input type="checkbox"/> |                                     |
| <b>I. Хуулийн этгээд</b>                                                                                                                                                                                                                                                                                                                 |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| Хуулийн этгээдийн нэр                                                                                                                                                                                                                                                                                                                    |  | Регистрийн дугаар |                                                                                                                                | Хяналтын байгууллагаас олгосон бүртгэлийн дугаар                      |                                     |
| Хаяг                                                                                                                                                                                                                                                                                                                                     |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| Аймаг/нийслэл                                                                                                                                                                                                                                                                                                                            |  | Сум/дүүрэг        |                                                                                                                                | Баг/хороо, гудамж, байр                                               |                                     |
| Хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, утас                                                                                                                                                                                                                                                             |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| Утасны дугаар-1                                                                                                                                                                                                                                                                                                                          |  | Утасны дугаар-2   |                                                                                                                                | Факсын дугаар                                                         |                                     |
| Цахим шуудан /e-mail/                                                                                                                                                                                                                                                                                                                    |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| Тусгай зөвшөөрөл олгосон сайдын тушаалын огноо, дугаар:                                                                                                                                                                                                                                                                                  |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| <b>II. Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ</b>                                                                                                                                                                                                                                                                                          |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| Бүтээгдэхүүний нэр төрөл                                                                                                                                                                                                                                                                                                                 |  | Тоо, хэмжээ, л    | Барааны ангиллын код                                                                                                           | Бүс нутаг, улс                                                        | Этилийн спиртийн ангилал, хэмжээ, % |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                          |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| Тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа, огноо                                                                                                                                                                                                                                                                                                 |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| он                                                                                                                                                                                                                                                                                                                                       |  | сар               |                                                                                                                                | өдөр                                                                  |                                     |
| <b>III. Импортлогчийн талаарх мэдээлэл</b>                                                                                                                                                                                                                                                                                               |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| Худалдааны гэрээ /Улс, байгууллагын нэр, огноо, дугаар/                                                                                                                                                                                                                                                                                  |  |                   | Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн төрөл, боомт, хугацаа                                                                    |                                                                       | Ажиллагсдын тоо                     |
| <input type="checkbox"/> Агуулахын байршил, хүчин чадал, м.кв, зэрэглэл*:                                                                                                                                                                                                                                                                |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| <input type="checkbox"/> Нэгдсэн агуулах<br><input type="checkbox"/> Төрөлжсөн агуулах:<br><input type="checkbox"/> Чийг тохируулгатай<br><input type="checkbox"/> Хүйтэн тохируулгатай<br><input type="checkbox"/> Халуун тохируулгатай:<br><input type="checkbox"/> Төвлөрсөн халаалт<br><input type="checkbox"/> Өөрийн халаалт ..... |  |                   | Агуулах:<br><input type="checkbox"/> Автоматжуулсан<br><input type="checkbox"/> Механикжсан<br><input type="checkbox"/> Энгийн |                                                                       |                                     |
| <b>IV. Дагалдах бичиг баримтууд</b>                                                                                                                                                                                                                                                                                                      |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| <b>Согтууруулах ундаа импортлох:</b>                                                                                                                                                                                                                                                                                                     |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| <input type="checkbox"/> Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ                                                                                                                                                                                                                                                                    |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| <input type="checkbox"/> Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт                                                                                                                                                                                                                                                                          |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| <input type="checkbox"/> Цагдаагийн байгууллагын санал                                                                                                                                                                                                                                                                                   |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |
| <input type="checkbox"/> Импортлох согтууруулах ундааны дээжийг нь хилийн гаалийн эрүүл ахуйн хяналт шалгалт                                                                                                                                                                                                                             |  |                   |                                                                                                                                |                                                                       |                                     |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |              |      |                   |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|------|-------------------|
| хийлгүүлэн баталгаажуулсан баримт, дүгнэлт                                                                                                                                                                                                                                                                                                           |              |      |                   |
| <input type="checkbox"/> Импортлох согтууруулах ундааны дээжийг мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, эрүүл ахуйн нөхцөл, эрүүл мэндийн дүгнэлтийг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас согтууруулах ундааны төрөл тус бүрээр гаргуулсан баримт, хяналтын хуудасны хуулбар /эсхүл эрсдлийн үнэлгээ/ |              |      |                   |
| <input type="checkbox"/> Тохирлын гэрчилгээний хуулбар /Импортлох согтууруулах ундаа нь Улсын техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан тухай Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвийн дүгнэлт, тодорхойлолт                                                            |              |      |                   |
| <input type="checkbox"/> ГЕГ-ийн гаалийн мэдээллийн санд зөрчил бүртгэгдсэн эсэх талаарх тодорхойлолт                                                                                                                                                                                                                                                |              |      |                   |
| Экспортлогч улсын үйлдвэртэй шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээний хуулбар, тухайн согтууруулах ундааг экспортлох зөвшөөрөл                                                                                                                                                                              |              |      |                   |
| <input type="checkbox"/> Импортлох хүнс нь зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо /аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт, хүнсний чанарын удирдлага, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын удирдлага/-г нэвтрүүлснийг баталгаажуулсан баримт                                                                              |              |      |                   |
| <input type="checkbox"/> Тухайн согтууруулах ундааг экспортлох зөвшөөрөл                                                                                                                                                                                                                                                                             |              |      |                   |
| <b>V. Тэмдэглэл</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                  |              |      |                   |
| Хүлээлгэн өгсөн ажилтан                                                                                                                                                                                                                                                                                                                              |              |      |                   |
| Нэр                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Албан тушаал | Утас | Гарын үсэг, тамга |
